



ДОРНОД АЙМАГ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 04 сарын 21 өдөр

Дугаар #11

Чойбалсан

“Үзүүлэх сургууль зохион байгуулах
тухай”

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 12.4, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг эрчимжүүлэхэд бидний манлайлал” үзүүлэх сургуулийг 2022 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр зохион байгуулсугай.

2.Үзүүлэх сургуулийн удирдамжийг нэгдүгээр, хөтөлбөрийг хоёрдугаар, төсвийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Үзүүлэх сургуулийн бэлтгэл ажлыг хангаж ажиллахыг Эмнэлгийн тусламжийн хэлтсийн дарга Ч.Оюунтунгалаг, Дашбалбар сумын Эрүүл мэндийн төвийн дарга Б.Алтанцэцэг нарт даалгасугай.

4.Батлагдсан төсвийг холбогдох зардлаас санхүүжүүлж ажиллахыг Ахлах нягтлан бодогч Б.Оджаргалд зөвшөөрсүгэй.

ДАРГА



Ч.ОЮУНАА

Эрүүл мэндийн газрын даргын 2022 оны
04 дугаар сарын 27-ны/ний өдрийн
8/11 дугаар/дүгээр тушаалын
нэгдүгээр хавсралт



**“ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ
ЭРЧИМЖҮҮЛЭХЭД БИДНИЙ МАНЛАЙЛАЛ” ҮЗҮҮЛЭХ СУРГУУЛИЙН
УДИРДАМЖ**

Үндэслэл: Статистик мэдээгээр эмнэлгийн 10 үйлчлүүлэгч тутмын 1 нь эмнэлгийн ямар нэгэн алдаа зөрчилд өртөж эрүүл мэнд, цаашлаад амь насаараа хохирч байдгаас улс орнуудад эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар аюулгүй байдлыг сайжруулах олон систем, хөтөлбөрүүд хэрэгжүүлж байна.

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, үйлчлүүлэгчийн болон үйлчилгээ үзүүлэгчийн аюулгүй байдлыг цогцоор нь тасралтгүй сайжруулах шаардлага зүй ёсоор тавигдсаар л байна. Эрүүл мэндийн байгууллага бүрт Чанар аюулгүй байдлын алба, багууд ажиллаж эмнэлгээс шалтгаалсан эрсдэл, зөрчлийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлэн ажиллаж байгаа нь эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, үйл ажиллагааг эрчимжүүлж буй тод жишээ юм.

Тиймээс үйл ажиллагааны цар хүрээг нэмэгдүүлж шинэ санал, санаачилга дэвшүүлэн чанаржуулж ажиллах хэрэгцээ шаардлага бидэнд байна. ЭМЯ-аас 2022 оныг эрүүл мэндийн салбарын хэмжээнд “Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах жил” болгон зарласан нь тус асуудалд анхаарлаа хандуулах, үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатайг онцлон илтгэж байна.

Зорилго: Дашбалбар сумын Эрүүл мэндийн төвийн чанар аюулгүй байдлын баг, сувилахуйн багаас хэрэгжүүлж буй эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар аюулгүй байдлын удирдлага, зохион байгуулалт, иргэдэд үзүүлж буй тусламж үйлчилгээний тэргүүн туршлагыг түгээн дэлгэрүүлж сурталчлах.

Зохион байгуулагч:

- Аймгийн Эрүүл мэндийн газар,
- Дашбалбар сумын Эрүүл мэндийн төв

Хамрах хүрээ: 13 сумын Эрүүл мэндийн төвийн чанар аюулгүй байдлын баг, сувилахуйн багийн гишүүдээс оролцох ба оролцогчид эмнэлгийн дүрэмт хувцастай ирэх

Хугацаа: 2022 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр Дашбалбар сумын Эрүүл мэндийн төвд

Хэрэгжүүлэх арга хэмжээ, үйл ажиллагааны чиглэл:

1. Дашбалбар сумын Эрүүл мэндийн төвтэй танилцах үйл ажиллагаа-
Б.Алтанцэцэг - Дашбалбар сумын Эрүүл мэндийн төвийн дарга

2.Эрүүл мэндийн яамнаас болон аймгийн Эрүүл мэндийн газраас зорилтот жилийн хүрээнд зохион байгуулах эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдал болон сувилахуйн тусламж үйлчилгээний чиглэлээр хийх үйл ажиллагааны чиглэл танилцуулах-Ч.Оюунтунгалаг-Эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусламжийн хэлтсийн дарга, Л.Сугар-Эрүүл мэндийн газрын Сувилахуйн мэргэжилтэн.

3.Дашбалбар сумын Эрүүл мэндийн төвийн Чанар, аюулгүй байдлын баг, сувилахуйн багийн үйл ажиллагааны танилцуулга хийх-Г.Мөнх-Алдар–Чанар аюулгүй байдлын багийн ахлагч, Д.Насанцэцэг-Сувилахуйн багийн ахлагч.

4.Үзүүлэх сургуулилтад оролцогчдын дунд “Чанар сайжруулах арга замууд” сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулах.

5.Бүлгийн ажлын танилцуулга

6.Санал хүсэлт, асуулт хариулт

7.Үзүүлэх сургуулийн хаалт

Үр дүн:

-Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах үйл ажиллагаа эрчимжинэ.


-Салбар дундын хамтын ажиллагаа нэмэгдэнэ.

-Шинэ санал санаачилга гарган ажиллах идэвхи сайжирна.

-“Сайн туршлага” түүнийг түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагаа эрчимжиж эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж нэмэгдэнэ.

ooOoo

Эрүүл мэндийн газрын даргын 2022 оны
 04... дүгээр сарын 26...ны/ний өдрийн
 А/11... дугаар/дүгээр тушаалын
 хоёрдугаар хавсралт



**ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ
 ЭРЧИМЖҮҮЛЭХЭД БИДНИЙ МАНЛАЙЛАЛ” ҮЗҮҮЛЭХ СУРГУУЛИЙН ХӨТӨЛБӨР**

Зохион байгуулагч: Эрүүл мэндийн газар, Дашбалбар сумын Эрүүл мэндийн төв
Байршил: Дашбалбар сумын эрүүл мэндийн төв

Хугацаа	Хийгдэх үйл ажиллагаа	Зохион байгуулагч
2022 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр		
15:00-16:00	Эрүүл мэндийн газраас Дашбалбар сум руу хөдлөх	Сургалтад оролцогчид
19:00-20:00	Үзүүлэх сургуулилтад оролцогчдыг угтан авах, байрлуулах	Дашбалбар СЭМТ-ийн хамт олон
2022 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр		
08:00-08:30	Өглөөний цай	Дашбалбар СЭМТ
08:30-09:00	Үзүүлэх сургуулилтын нээлт	ЭМГ, ЭТХ-ийн дарга Ч.Оюунтунгалаг
09:00-09:30	Сумын Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаатай танилцах	Дашбалбар СЭМТ-ийн дарга Б.Алтанцэцэг
09.30-10:30	ЭМЯ болон аймгийн ЭМГ-аас зорилтот жилийн хүрээнд зохион байгуулах эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдал болон сувилахуйн тусламж үйлчилгээний чиглэлээр хийх үйл ажиллагааны чиглэл танилцуулах	ЭМГ ЭТХ-ийн дарга Ч.Оюунтунгалаг Мэргэжилтэн Л.Сугар
10.30-11:30	Дашбалбар СЭМТ-ийн Чанар, аюулгүй байдлын баг, сувилахуйн багийн үйл ажиллагааны танилцуулга хийх	Г.Мөнх-Алдар /ЧАБ-ын багийн ахлагч/ Д.Насанцэцэг/ Сувилахуйн багийн ахлагч/
11:30-11:45	Цайны засварлага	
11:45-12:45	“Чанар сайжруулах арга замууд” сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулах /бүлгийн ажил/	Зохион байгуулагчид
12:45-13:00	Сэргээх дасгал	Зохион байгуулагчид
13:00-14:00	Үдийн завсарлага	
14:00-15:30	Бүлгийн ажлын танилцуулга	Нийт оролцогчид
15.30-17.00	Санал хүсэлт, асуулт хариулт, үзүүлэх сургуулийн хаалт	Нийт оролцогчид

Жич: Үзүүлэх сургуулийн үйл ажиллагаагаар ТВ-ийн бичлэг хийх